



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 10 дугаар хорооны
“Ариун чанар” өрхийн эрүүл мэндийн төвийн
хуучин барилгыг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/71 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/685 дугаар захирамж, “Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянгол дүүргийн 10 дугаар хорооны “Ариун чанар” өрхийн эрүүл мэндийн төвийн баланст бүртгэлтэй 28,382,780.00 (хорин найман сая гурван зуун наян хоёр мянга долоон зуун наян) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, 6,208,733.00 (зургаан сая хоёр зуун найман мянга долоон зуун гучин гурав) төгрөгийн үлдэх өртөгтэй хуучин өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн 10 дугаар хорооны “Ариун чанар” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тогтоол, захирамжийг үндэслэн газар эзэмших эрхийг байгууллагын нэр дээр шилжүүлэн авах ажлыг зохион байгуулан ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн ДТХГ дугаар тушаалын хавсралт

Балансаасбаланст шилжүүлэх барилга

№	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2025.03.31/	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Баянгол дүүргийн 10 дугаар хорооны Ариун дугаар хороо, Имарт чанар" ерхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга	Баянгол дүүргийн 10 дугаар хороо, Имарт худалдааны төвийн чанх хойно, замын хойд талд	2001	м2	108	28,382,780.00	22,174,047.00	6,208,733.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
	Шилжүүлэх хөрөнгийн дүн					28,382,780.00	22,174,047.00	6,208,733.00	